



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

«Дүрэм, бүрэлдэхүүн, аргачлал батлах тухай»

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, “Ашигт малтмалын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар, бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Уул уурхайн сайдын “Дүрэм, бүрэлдэхүүн, аргачлал батлах тухай”2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/55 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

Гурав.Энэхүү дүрмийг батлагдсан өдрөөс хүчин төгөлдөрт тооцох бөгөөд хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Одхүүд)-т даалгасугай.



Ц.ДАШДОРЖ

08 0070

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 09 дугаар сарын 08-ны
өдрийн 08 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт




ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 "Ашигт малтмалын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9, 48 дугаар зүйлийн 48.4, "Газрын тосны тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 9 дүгээр зүйлийн 9.1.5 болон 9.1.11, "Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, "Цөмийн энергийн тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.5 дах заалтыг тус тус үндэслэн мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх үүрэг бүхий "Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл" /цаашид "Зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.
- 1.2 Зөвлөл нь дараахь асуудлыг хэлэлцэж, холбогдох хууль тогтоомж, судалгааны арга, аргачлал, заавар, журамд нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргаж, зөвлөмж өгнө. Үүнд:
 - Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөл, төсөв түүний жил бүрийн тодотгол, эцсийн үр дүнгийн тайлан, ашигт малтмалын баялгийн үнэлгээнд,
 - Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн гүйцэтгэсэн ордын нөөцийн тооцоолол, эдийн засгийн урьдчилсан үнэлгээ бүхий хайгуулын ажлын үр дүнгийн тайлан /ус, рашаанаас бусад ашигт малтмал/-д,
 - Ашиглалтанд бэлтгэгдсэн ордыг ашиглах болон хүдрийг баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл (цаашид "ТЭЗҮ" гэх)-д,
 - Газрын тос (газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тос, нүүрсний давхаргын метан хий)-ны судалгаа, хайгуулын ажлын үр дүнгийн тайланд,
 - Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө ("ТЭЗҮ" гэж ойлгоно)-д
- 1.3 Зөвлөл нь хуралдааны хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4 Зөвлөл нь асуудлыг хамтын журмаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрийг гаргана.
- 1.5 Зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж байна.
- 1.6 Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 29 дугаар сарын 27-ны
өдрийн 23 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт



Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг

2.1. Зөвлөл нь дараах нийтлэг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Дүрмийн 4.1.1-д заасан салбар хуралдаанаар геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлан хэлэлцэхдээ Монголын стратиграфын комиссоос гаргасан дүгнэлт, зөвлөлөөс томилогдсон хоёроос доошгүй шинжээчийн шүүмжийг үндэслэн геологийн зургийг жишигт тохирсон эсэх, судалгааны арга, аргачлал нь оновчтой эсэх, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа арга аргачлалтай нийцэж буй эсэх мөн энэхүү судалгаанд зарцуулсан зардлыг тухайн хуулийн этгээдийн санхүүгийн тайлан тэнцэлд хэрхэн тусгах талаар хуралдааны тэмдэглэл, дүгнэлт, зөвлөмжид тодорхой зааж өгөх;

2.1.2. Дүрмийн 4.1.1-д заасан салбар хуралдаанаар ашигт малтмалын ордын хайгуулын ажил, үр дүнгийн тайланг Ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагааны журам, нөөцийн ангилалд нийцүүлэн гүйцэтгэж, боловсруулсан эсэхийг шинжээчийн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр хэлэлцэн уг ордын нөөцийг хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх асуудлаар хуралдааны тэмдэглэл хөтөлж дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.1.3. Дүрмийн 4.1.1-д заасан салбар хуралдаанаар газрын тос (газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тос, нүүрсний давхаргын метан хий)-ны судалгаа, хайгуулын ажлаар тогтоогдсон нөөцийн тооцооны тайланг холбогдох заавар, журам, нөөцийн ангилалд нийцүүлэн гүйцэтгэж боловсруулсан эсэхийг шинжээчийн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр хэлэлцэн нөөцийг хүлээн авч ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх асуудлыг хуралдааны тэмдэглэл хөтөлж дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.1.4. Дүрмийн 4.1.2-т заасан салбар хуралдаанаар ашигт малтмалын ордыг ашиглах болон хүдрийг баяжуулах ТЭЗҮ-ийг хэлэлцэхдээ энэ дүрмийн 2.1.2-т заасан зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, оновчтой арга аргачлал, техник тоног төхөөрөмжийн шийдлээр судалгаа, шинжилгээний үндэслэлтэйгээр боловсруулсан эсэхийг шинжээчийн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр хэлэлцэн тэмдэглэл хөтөлж, ТЭЗҮ-г хүлээж авах эсэх тухай дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.1.5. Дүрмийн 4.1.2-т заасан салбар хуралдаанаар газрын тосны орд (газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тос, нүүрсний давхаргын метан хий)-ыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг энэхүү дүрмийн 2.1.3-т заасан зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, оновчтой арга аргачлал, техник тоног төхөөрөмжийн шийдлээр судалгаа, шинжилгээний үндэслэлтэйгээр боловсруулсан эсэхийг шинжээчийн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр хэлэлцэн үйл ажиллагааны төлөвлөгөөг хүлээж авах эсэх талаар дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.1.6 Зөвлөл нь "Ашигт малтмалын тухай" хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэгт заасны дагуу 30 хоногт багтаан шинжээчийг томилно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 19 дугаар сарын 21-ны
өдрийн 23 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт



2.1.7. Зөвлөлөөс томилогдсон шинжээч нь Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлаар мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

2.1.8. Зөвлөлийн дарга Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал болон гаргасан шийдвэрийн талаар Сайдын зөвлөлд улирал тутам танилцуулна.

2.2. Зөвлөл энэхүү дүрмийн 2.1-д заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлэхдээ дор дурдсан эрх эдэлнэ:

2.2.1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөл, төсөв, төсвийн тодотголыг "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын дагуу төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгжээр хянуулсны дараа, гүйцэтгэсэн ажлын эцсийн үр дүнгийн тайланг Монголын стратиграфын комиссын дүгнэлт, зөвлөлөөс томилогдсон шинжээчдээр шүүмж хийлгүүлж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр Зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэх;

2.2.2. Тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр хуулийн этгээдийн ирүүлсэн ашигт малтмал болон газрын тосны (газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тос, нүүрсний давхаргын метан хий) ордын нөөцийн ангилалд нийцүүлэн зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн ахлаж боловсруулсан ордын нөөцийн тооцоолол бүхий үр дүнгийн тайланд шинжээчийн дүгнэлт гаргуулж төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгжээр хянуулсны үндсэн дээр Зөвлөлийн холбогдох салбар хуралдаанаар хэлэлцэн зөвлөмж, дүгнэлтийг гаргах;


Газрын тосны ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайланд Монголын стратиграфын комиссын дүгнэлтийг заавал хийлгэсэн байна.

2.2.3. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдээс ирүүлсэн зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтнээр ахлуулсан бүрэлдэхүүнтэй эрх бүхий хуулийн этгээд нь холбогдох заавар, журам, шаардлагад нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулсан ордыг олборлох, хүдрийг баяжуулах ТЭЗҮ-ийг төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгжээр хянуулсны үндсэн дээр Зөвлөлийн холбогдох салбар хуралдаанаар хэлэлцэн зөвлөмж, дүгнэлт гаргах;

2.2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдээс ирүүлсэн зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтнээр ахлуулсан багийн холбогдох заавар, журам, шаардлагад нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулсан газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгжээр хянуулсны үндсэн дээр Зөвлөлийн холбогдох салбар хуралдаанаар хэлэлцэн зөвлөмж, дүгнэлт гаргах;

2.2.5. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн тайлан, материалын бүрдэл бүрэн бус, мөрдөгдөж байгаа заавар, журмын шаардлагыг

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 29 дугаар сарын 27-ны
өдрийн 203 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт



хангаагүй бол зөвлөлийн салбар хуралдааны нарийн бичгийн дарга тухайн этгээдэд буцаах,

2.2.6 Зөвлөлийн хуралдаанаар тайлан материалыг хэлэлцэх явцад буцаахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрийн шалтгаан, нөхцөл байдлын талаар тодорхой тусгасан дүгнэлтийг гаргах;

2.2.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн тайлан, ТЭЗҮ-ийг Зөвлөлийн хуралдаанаас хэлэлцэх явцад хайгуулын ажлаар тогтоосон болон ТЭЗҮ, газрын тосыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан зарим үзүүлэлтэд хяналт хийх, тодруулах шалгах шаардлагатай асуудал гарсан тохиолдолд Зөвлөлөөс холбогдох шийдвэрийг гаргаж, тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

2.2.8. Шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаар холбогдох эрдэмтэн, мэргэжилтнүүдийг зөвлөлдөх, санал сонсох эрхтэйгээр Зөвлөлийн хуралдаанд урьж, оролцуулна.

2.2.9. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын геологийн даалгаврыг хангалтгүй биелүүлснээс судалгааны ажлын чанар, үнэмшил тавьсан шаардлагад хүрээгүй тохиолдолд Зөвлөлийн хуралдаанаас энэ тухай дүгнэлт гаргаж, тухайн ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний дагуу нөхөн төлбөр, мөнгөн торгууль ногдуулах болон цаашид төсөл хэрэгжүүлэгчээр оролцох боломжгүй болох талаарх дүгнэлтийг захиалагчид уламжлах, харин төслийг амжилттай хэрэгжүүлсэн тохиолдолд урамшуулах асуудлыг "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын дагуу холбогдох байгууллагуудад уламжлаж шийдвэрлүүлэх:

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Зөвлөл нь "Газрын хэвлийн тухай", "Ашигт малтмалын тухай", "Газрын тосны тухай", "Цөмийн энергийн тухай", "Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай" хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн үйл ажиллагаа явуулах бөгөөд геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан энэхүү дүрэм, дотоод журмыг мөрдөж ажиллана.

3.2. Зөвлөлийн салбар хуралдааны гишүүд нь геологи, газрын тос, уул уурхайн болон эдгээр салбарын эдийн засгийн чиглэлийн мэргэжлийн туршлага бүхий зөвлөх ба мэргэшсэн мэргэжилтэн, улс төрийн бус албан тушаалтан байх бөгөөд бусад салбар зөвлөлийн гишүүн байж болно.

3.3. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, салбар хуралдааны дарга нарыг удирдлагын бүрэлдэхүүн гэж ойлгоно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 09 дугаар сарын 21-ны
өдрийн 28 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

3.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тушаалаар салбар хуралдаан тус бүрээр батлах бөгөөд салбар хуралдааны гишүүдийн бүрэлдэхүүнийг өөрчлөх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Зөвлөлийн дарга саналаа сайдад танилцуулан шийдвэрлүүлнэ.

3.5. Зөвлөлийн салбар хуралдааны бүрэлдэхүүнийг хуралдаанд оролцсон байдал, ирцийг харгалзан 30 хүртэлх хувийг жил бүр шинэчлэн тогтоож болно.

3.6. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Төрийн захиргааны албан хаагчийн эзлэх хувь дийлэнх олонхи байна.

3.7. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц, түүнийг ашиглах ТЭЗҮ-ийг хэлэлцэх, мөн шаардлагатай гэж үзсэн зарим хуралдаанд УИХ, Засгийн газрын холбогдох гишүүд, яам, агентлаг, эрдэм шинжилгээний байгууллага зэргээс холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг саналын эрхгүйгээр урилгаар оролцуулж болох ба оролцох бүрэлдэхүүнийг Зөвлөлийн дарга, салбар хуралдааны дарга нар тогтооно.

3.8. Геологийн судалгаа, ашигт малтмалын ордын хайгуулын ажлын тайлан, нөөцийн тооцоолол бүхий ордын тайлан, ордыг ашиглах болон хүдрийг баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ, газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэгт шүүмж, мэргэжлийн дүгнэлт гаргах шинжээч болон шинжээчдийн хэсгийг тухайн асуудал хариуцсан салбар хуралдааны даргын саналыг үндэслэн, зөвлөлийн дарга томилно.

3.9. Стратегийн ач холбогдол бүхий ордын хайгуулын ажлын тайлан, нөөц тооцоолол, ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд шүүмж, дүгнэлт гаргах эрдэмтэд, мэргэжилтнүүдийг оролцуулсан шинжээчдийн хэсгийг геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тушаалаар томилно.

3.10. Зөвлөлийн хуралдаанаар тайлан, ТЭЗҮ, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа аливаа хуулийн этгээд нь томилогдсон шинжээчийг тухайн асуудалтай холбоотой мэдээллээр бүрэн хангана.

3.11. Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, агентлагийн даргын тушаалаар Зөвлөлийн хуралдааны дүгнэлт, зөвлөмжтэй холбогдуулан гаргасан үүрэг, даалгаврын биелэлтийг Яам, агентлагийн холбогдох нэгж, тухайн хуулийн этгээд тогтоосон хугацаанд гарган Зөвлөлийн даргад ирүүлсэн байна. Зөвлөл нь өмнөх хуралдааны шийдвэр, түүний биелэлтийг хангаж ажиллаагүй хуулийн этгээдтэй холбоотой асуудлыг хэлэлцэхгүй.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 09 дугаар сарын 09-ны
өдрийн 02 дүгээр тушаалын
нэгдүгээр хэвсрэлт

3.12. Зөвлөлийн хуралдаанаар тухайн асуудлыг хэлэлцүүлэхтэй холбогдон гарах зардал (улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланд шүүмж бичсэн шинжээч, гишүүдэд хуралдаанд оролцсон тухайд нь олгох ажлын хөлс, Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдож гарах бусад зардал г.м)-ыг зохих журмаар батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлнэ.

3.13. Ашигт малтмалын ордын хайгуулын ажлаар тогтоосон нөөцийн тооцооны тайлан, ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ, газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөндлөнгийн дүгнэлт гаргах шинжээчийн ажлын зардал, хөлсийг тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу тухайн хуулийн этгээд хариуцна.

3.14. Шинжээчийн ажлын хөлсийг дүгнэлт гаргуулахаар ЭБМЗ-д хандсан холбогдох тайлан, ТЭЗҮ, төлөвлөгөө болон шинжээчийн хийх ажлын хэмжээ зэргийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалаар тогтооно.

3.15. Зөвлөлийн хуралдаанаас гарах дүгнэлт, зөвлөмжийг тухайн хуралдааны нарийн бичгийн дарга боловсруулж Зөвлөлийн дарга болон салбар хуралдааны дарга нар хянаж баталгаажуулна.

3.16. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи, эрдэс баялгийн судалгааны ажлын төсөл, төсвийн тодотгол, эцсийн үр дүнгийн тайлан, стратегийн ач холбогдол бүхий ордын нөөцийн тооцооллын тайлан, түүний ТЭЗҮ-ийг хүлээн авах тухай шийдвэрийг Зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, бусад холбогдох асуудлыг Зөвлөлийн салбар хуралдааны дүгнэлтийг үндэслэн геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга тушаал гаргана.

3.17. Салбар хуралдааны нарийн бичгийн дарга нараас хариуцсан асуудлын чиглэлээр ирүүлсэн мэдээ, тайлан, тэмдэглэл, зөвлөмж, дүгнэлтийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга нэгтгэн Зөвлөлийн даргад танилцуулж хянуулна.

3.18. Салбар хуралдааны нарийн бичгийн даргыг тухайн салбар хуралдааны даргын санал болгосноор геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар томилох ба нарийн бичгийн дарга нь хуралд санал өгөх эрхгүйгээр оролцоно.

3.19. Хуралдааны шийдвэр, бусад холбогдох материалыг салбар хуралдааны нарийн бичгийн дарга 7 хоногт багтаан албажуулж зохих хуулийн этгээд, албан тушаалтан, холбогдох иргэнд хүргүүлнэ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 00 дугаар сарын 01-ны
өдрийн 203 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

3.20 Хуульд заасан эрх бүхий байгууллагаас Зөвлөлтэй холбоотой асуудлаар маргаан шийдвэрлэх, хяналт, шалгалт хийх тохиолдолд тухайн асуудал хариуцсан Зөвлөлийн нарийн бичгийн дарга шаардлагатай баримт, мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээх ба тус байгууллага нь үр дүнг хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа Зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ. Зөвлөл нь тухайн шийдвэрийг хүлээн авч өөрийн эрх үүргийн хүрээнд холбогдох шийдвэрийг гаргана.

Дөрөв. Зөвлөлийн салбар хуралдааны хэлэлцэх асуудал

4.1. Зөвлөл хэлэлцэх асуудлын онцлогтой уялдсан дараах салбар хуралдаанаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлтийг гаргана. Үүнд:

4.1.1. Геологийн судалгаатай холбоотой асуудлыг /цаашид "Геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуулын асуудал" гэнэ/ хэлэлцэх Зөвлөлийн салбар хуралдаанаар:

4.1.1.1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, тэдгээртэй адилтгах бусад судалгааны ажлын төсөл, төсөв, түүний төсөл, төсвийн тодотгол, эцсийн үр дүнгийн тайлан;

4.1.1.2 Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлага,

4.1.1.3 Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгөөр болон хувийн хөрөнгөөр хийж байгаа газрын тосны судалгаа, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан:

4.1.1.4 Улсын төсвийн болон хувийн хөрөнгөөр хийж байгаа газрын тосны судалгаатай холбогдолтой дүрэм, журмын төсөл, арга аргачлал, патент,

4.1.1.5 "Ашигт малтмалын тухай" хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 болон 48.6.3-т заасны дагуу ирүүлсэн ашигт малтмалын баялгийн үнэлгээ, ордын нөөцийн тооцоолол, эдийн засгийн урьдчилсан үнэлгээ бүхий хайгуулын ажлын үр дүнгийн тайлан:

4.1.1.6. Монгол Улсын хатуу ашигт малтмалын тухайн жилд нэмэгдсэн болон хасагдсан ашигт малтмалын нөөцийг улсын нөөцийн хөдөлгөөний тэнцэлд тусгуулах:

4.1.1.7. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу гүйцэтгэсэн газрын тосны судалгааны ажлын үр дүнд тогтоосон газрын тос, байгалийн хийн нөөц түүнтэй холбоотойгоор тухайн жилд нэмэгдсэн болон хасагдсан нөөцийг улсын нөөцийн хөдөлгөөний тэнцэл (баланс)-д тусгуулах;

4.1.2. Ашигт малтмалын ашиглалт, олборлолт, хүдрийг баяжуулах ТЭЗҮ зэрэг уул уурхайн үйлдвэрлэлтэй холбогдолтой асуудлыг /цаашид "Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ, үйл ажиллагааны төлөвлөгөөний асуудал" гэнэ./ хэлэлцэх Зөвлөлийн салбар хуралдаанаар:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 09 дугаар сарын 21-ны
өдрийн 213 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

4.1.2.1. Уул уурхайн үйлдвэрлэлийн техник, технологийг боловсронгуй болгох, ашигт малтмалыг олборлон ашиглах явцад гарах хаягдлыг багасгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэгт чиглэсэн судалгаа;

4.1.2.2. Орд газрыг олборлох, хүдрийг баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл,

4.1.2.3. Уул уурхайн үйлдвэрлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлага, хүлээн авах заавар;

4.1.2.4. Газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тос олборлох, газрын тос боловсруулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл;

4.1.2.5. Газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө.

Тав. Хуралдааны дэг

5.1. Зөвлөлийн болон салбар хуралдааны бэлтгэл хангуулах ажлыг тухайн асуудал хариуцсан зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.

5.1.1. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг нэгтгэн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга салбар Зөвлөлийн даргад урьдчилан танилцуулж зөвшөөрөл авна. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хууль тогтоомжид нийцсэн, зохих судалгаа, тооцоо, нотлох баримтад бүрэн үндэслэсэн холбогдох байгууллагын санал, дүгнэлтээр баталгаажиж, бүрэн гүйцэд боловсруулсан албан хэрэг хөтлөлтийн болон архивын ажлын үндсэн зааврын шаардлагын дагуу бэлтгэгдсэн, хуралдаанд танилцуулах бүрдэл, шаардлага хангасан материалыг хүлээн авна. Хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн материал нь дээр дурдсан бүрдэл, шаардлагыг хангаагүй гэж үзвэл тодорхой үндэслэл, тайлбарыг гарган буцаана.

5.1.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг тухайн хуралдааныг удирдан явуулах зөвлөлийн болон салбар хуралдааны дарга тогтоож хөтөлбөрийг батална.

5.1.3. Зөвлөлийн болон салбар хуралдааны дарга нь хуралдаан болох өдөр, цагийг товлон.

5.1.4. Нарийн бичгийн дарга нь хуралдаанаар хэлэлцэх асуудлын хөтөлбөр, холбогдох бусад материалыг олшруулж, уг асуудлыг хэлэлцэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө Зөвлөлийн гишүүдэд танилцуулахаар хүргүүлсэн байна.

5.1.5. Зөвлөлийн гишүүд хуралдаанаар хэлэлцэх асуудлын материалтай бүрэн танилцаж, саналаа бэлтгэж ирнэ.

5.1.6. Хуралдааны зохион байгуулалт, байрны нөхцөл, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах ажлыг тухайн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга хариуцан гүйцэтгэнэ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны дугаар сарын.....-ны
өдрийн..... дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

1116127151
УХА0580 9129294

5.2. Хуралдаан нь хууль дээдлэх ёс, шударга ёс, хамтын удирдлагын зарчмыг баримтлан цөөнхийн саналыг хүндэтгэн, олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

5.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, түүнтэй холбоотой тайлан, ТЭЗҮ-г хэлэлцэх хуралдааныг Зөвлөлийн дарга, бусад асуудлыг хэлэлцэх хуралдааныг салбар зөвлөлийн дарга даргална. Зөвлөлийн даргын эзгүйд түүний эрх олгосноор тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой салбар зөвлөлийн дарга хуралдааныг даргална.

5.4. Зөвлөл нь шийдвэр гаргахдаа хараат бус байдлыг хангах үүднээс тухайн аж ахуйн нэгжийг хуралдааны танхимаас гаргаж илээр санал хураана.

5.5 Зөвлөлийн гишүүн нь хуралд биечлэн оролцож саналаа өгсөн тохиолдолд уг саналыг хүчин төгөлдөрт тооцно.

5.5.1 Зөвлөлийн гишүүн хэлэлцэж байгаа асуудалд зөвхөн "зөвшөөрсөн", "татгалзсан" хоёр саналын аль нэгийг өгнө.

5.5.2 Хуралдааны явцад зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авсан тохиолдолд өөрийн саналыг бичгээр нарийн бичгийн даргад гарган өгнө. Бичгээр санал өгөхдөө зөвшөөрсөн, татгалзсан тухай тодорхой бичнэ.

5.5.3 Зөвлөлийн гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой ашиг сонирхлын зөрчилд орж болзошгүй гэж үзсэн тохиолдолд санал өгөх эрхгүй бөгөөд тухайн асуудлыг хэлэлцэх хуралдаанд оролцохгүй.

5.6 Тухайн хуралдаанд оролцох салбар зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь ирсэн тохиолдолд хуралдааны ирцийг бүрдсэнд тооцож хуралдааныг зохион байгуулна.

5.7 Зөвлөлийн хуралдааныг ажлын өдрүүдэд, монгол хэлээр явуулна.

5.8 Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцоогүй Зөвлөлийн гишүүдэд Хуралдааны материал, гаргасан шийдвэрийг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга тухай бүр нь танилцуулж байна.

5.9 Хуралдааны явцын дэлгэрэнгүй тэмдэглэлийг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд түүнд тухайн салбар зөвлөлийн дарга гарын үсгээ зурж албажуулна.

5.10 Хэрэв салбар зөвлөлийн дарга хүндэтгэн үзэх шалтгаанаар хурал даргалах боломжгүй бол нөгөө салбар зөвлөлийн дарга орлож болно.

5.11 Энэхүү дүрмийн 5.10 дах заалтыг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд салбар зөвлөлийн дарга өөрийн эрх, үүргийг тухайн зөвлөлийн гишүүдийн нэгэнд шилжүүлж болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 09 дугаар сарын 21-ны
өдрийн 03 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

5.12 Хуралдааны тэмдэглэлд дор дурдсан зүйлийг тусгана:

- а/ Хуралдаан эхэлсэн, завсарласан, дууссан он, сар, өдөр, цаг, минут;
- б/ Хуралдаан болсон газар,
- в/ Ирцийн байдал (тоо, хувиар), хуралдаанд оролцоогүй гишүүний нэр, шалтгаан;
- г/ Хуралдаанаар тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцсон, байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал,;
- д/ Хэлэлцсэн асуудал, түүнийг танилцуулсан хүний нэр, албан тушаал,;
- е/ Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсон асуулт, хариулт, гаргасан санал, шүүмжлэл, хэлсэн үгийн товч утга;
- ж/ Хуралдаанд хоцорч ирсэн, хуралдааны дундуур чөлөө авч явсан гишүүний нэр, цаг, минут ба түүний бичгээр өгсөн санал;
- з/ Саналын зөрүүтэй асуудлаар болон гарах шийдвэрийн төслийн утга, агуулга, энэ асуудлаарх санал хураалтын дүн (тоо, хувиар);
- и/ Гарсан шийдвэрийн агуулга (утга);
- к/ Зөвлөлийн гишүүний тусгайлан тэмдэглүүлэхээр хэлсэн үг болон өөрөө бичиж өгсөн санал.

5.13 Хуралдаанаар хэлэлцсэн асуудал тус бүрээр энэ журмын 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.4-т заасан дүгнэлт, зөвлөмж гаргахдаа салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, салбар зөвлөлийн болон зөвлөлийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.

Зургаа. Шинжээчийн эрх, үүрэг

6.1. Шинжээч нь геологи, газрын тос, уул уурхайн салбарын мэргэжлийн зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй, улс төрийн албан тушаалтан бус, мэргэжлийн болон ёс зүйн зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй зэрэг шаардлагыг хангасан байна.

6.2. Зөвлөлийн гишүүнийг стратегийн ач холбогдол бүхий орд болон тухайн бүс нутгийн хөгжилд эдийн засгийн ач холбогдол бүхий ордын тайлан, ТЭЗҮ-д шүүмж, дүгнэлт хийх шинжээчдийн хэсэгт жилдээ хоёр хүртэл, эрх бүхий мэргэшсэн мэргэжилтэн, зөвлөхийг жилдээ дөрөв хүртэл удаа шинжээчээр томилж болно. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажил, түгээмэл тархацтай ашигт малтмалын тайланд шинжээч хийх асуудалд энэ заалт хамаарахгүй.

6.3. Тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн хийж гүйцэтгэж буй геологийн судалгааны ажил болон орд ашиглах ТЭЗҮ, газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцдаа Зөвлөлд албан бичгээр хандан шинжээчийг томилуулж болох бөгөөд шинжээч нь геологийн

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 29 дугаар сарын 21-ны
өдрийн 23 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

судалгааны ажлын үр дүнгийн тайлан болон ТЭЗҮ, газрын тосны ордыг ашиглах төлөвлөгөөны боловсруулалтын бодит байдал, үнэмшилд хяналт тавих хэлбэрээр оролцоно.

1116127151
УХА0580 9129294

6.4. Шинжээчийн шүүмж, дүгнэлт гаргах хугацаа нь тухайн ажлын хэмжээ, шаардлагаас хамаарах бөгөөд 60 хоногоос хэтрэхгүй байна.

6.5. Шинжээч нь ажлын туршлага, мэргэжлийн ур чадвартаа тулгуурлан үр дүнгийн тайлан, ТЭЗҮ, газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан судалж, тухайн объект дээр нь ажиллан холбогдох журам, зааварт нийцэж байгааг шалган баталгаажуулж шүүмж, дүгнэлтээ үнэн, зөв, бодитой гарган, тайлан зохиогч болон зөвлөлийн нарийн бичгийн даргад ирүүлэх ба Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх үед өөрийн биеэр танилцуулна.

6.6. Шинжээч нь зөвлөлийн ажиллах дотоод журмаар батлагдсан "Шинжээчийн хяналтын хуудас"-ыг ашиглаж дүгнэлтээ гаргана.

6.7. Тухайн томилогдсон шинжээч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар шинжээчээс татгалзах эрхтэй, харин ашиг сонирхолын зөрчилтэй тохиолдолд шинжээчээр ажиллахаас татгалзах үүрэгтэй бөгөөд энэ тухай хүсэлтээ Зөвлөлд бичгээр хүргүүлнэ.

6.8. Шинжээч нь өөрийн гаргасан шүүмж, дүгнэлтээс үл хамааран хийсэн ажилдаа тохирсон хөлсийг авах эрхтэй.

6.9. Шинжээч нь үр дүнгийн тайлан, ТЭЗҮ, газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийсэн өөрийн шүүмж, дүгнэлтийг бүрэн хариуцна.

Долоо. Хариуцлага

7.1. Зохиогч болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь үр дүнгийн тайлан, ТЭЗҮ, үйл ажиллагааны төлөвлөгөөг санаатай хуурамчаар үйлдсэн тохиолдолд Зөвлөл энэ асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

7.2. Зөвлөлийн дарга, гишүүд нь илэрхий нэг талыг барьсан шийдвэр гаргасан талаар байгууллага, иргэдээс ирсэн гомдлыг Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж тухай бүр шалгаж, дүгнэлт гаргана

7.3. Зөвлөлийн дарга, салбар зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нь 7.2-т заасан зөрчлийг гаргасан нь тогтоогдсон бол зөрчлийн шинж

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 09 дугаар сарын 23-ны
өдрийн 23 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

байдлыг харгалзан Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж тухайн этгээдийг Зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөх, эсхүл сахилгын шийтгэл ногдуулахаар эрх бүхий этгээдэд санал хүргүүлж болно.

7.4. Шинжээч нь санаатай хуурамч дүгнэлт гаргасан тохиолдолд Зөвлөлийн дарга, зөвлөлийн салбар хуралдааны дарга нь зөрчил гаргасан шинжээчийн зөвлөх, мэргэшсэн зэргийг түдгэлзүүлэх асуудлыг тухайн эрх олгосон байгууллагад тавьж, шаардлагатай бол холбогдох хууль хяналтын байгууллагад хандана.

7.5. Зөвлөл нь гаргасан шийдвэртээ дангаар хариуцлага хүлээх бөгөөд тухайн асуудлыг хэлэлцсэн Зөвлөлийн өргөтгөсөн болон салбар хуралдааны гишүүд хамтын хариуцлага хүлээнэ.

7.6. Шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээр бол асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

----- ооо О ооо -----

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны дугаар сарын.....-ны
өдрийн дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт |а|



**Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн
Удирдлагын бүрэлдэхүүн**

Зөвлөлийн дарга:

- Ашигт малтмал, газрын тосны газрын дарга


Геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуултай холбоотой асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн дарга:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга

Ашигт малтмалын орд ашиглах, баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн дарга:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 05 дугаар сарын 21-ны
өдрийн 23 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт |б|



**“Геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуулын асуудал” хэлэлцэх
Салбар зөвлөлийн Геологийн судалгааны асуудлыг хэлэлцэх
гишүүдийн бүрэлдэхүүн**


Салбар Зөвлөлийн
дарга:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга

Гишүүд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын тухайн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын геологийн судалгааны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
- Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга \тохиролцсоноор\
- Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, хайгуулын хэлтсийн дарга
- Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, хайгуулын хэлтсийн тухайн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Ашигт малтмал, газрын тосны газрын Эрдэс баялгийн мэдээлэлийн технологийн төвийн дарга
- Монголын стратиграфийн комиссын төлөөлөл
- ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн төлөөлөл \тохиролцсоноор\ ,
- Монголын үйлдвэрлэлийн геологчдийн холбооны төлөөлөл \тохиролцсоноор\ ,
- Монголын геологийн холбооны төлөөлөл \тохиролцсоноор\

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 09 дугаар сарын 21-ны
өдрийн 03 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт |6|



**“Геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуулын асуудал” хэлэлцэх
Салбар зөвлөлийн Ашигт малтмалын хайгуултай холбоотой асуудлыг хэлэлцэх
гишүүдийн бүрэлдэхүүн**

- Салбар зөвлөлийн дарга: - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга
- Гишүүд:
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Түлшний бодлогын газрын дарга
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын тухайн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын тухайн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
 - Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, хайгуулын хэлтсийн дарга
 - Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн хэлтсийн дарга
 - Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, хайгуулын хэлтсийн тухайн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Геологийн төв лабораторийн төлөөлөл (тохиролцсоноор),
 - МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Геологи, Ашигт малтмалын хайгуулын салбарын төлөөлөл (тохиролцсоноор),
 - ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн төлөөлөл (тохиролцсоноор),

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 09 дугаар сарын 21-ны
өдрийн 023 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт |з|

**“Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ, үйл ажиллагааны төлөвлөгөөний
асуудал” хэлэлцэх салбар зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүн**

- Салбар зөвлөлийн дарга: - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга
- Гишүүд:
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Түлшний бодлогын газрын дарга
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
 - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга \тохиролцсоноор\ ,
 - Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга \тохиролцсоноор\ ,
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын ашиглалтын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
 - Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн хэлтсийн дарга
 - Ашигт малтмал, газрын тосны газрын Нүүрсний судалгааны хэлтсийн дарга
 - Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн хэлтсийн салбарын судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Уул уурхайн үндэсний ассоциацийн төлөөлөл \тохиролцсоноор\
 - ШУТИС-ийн харъяа Геологи уул уурхайн сургуулийн Уул уурхайн ашиглалтын технологийн зөвлөх профессор \тохиролцсоноор\
 - Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлийн гүйцэтгэх захирал \тохиролцсоноор\

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 09 дугаар сарын 21-ны
өдрийн 03 дүгээр тушаалын
гуравдугаар хавсралт



ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ХӨЛС ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ аргачлалын зорилго нь шинжээчийн ажлын хөлсний жишгийн үндэслэлийг тогтооход оршино.
- 1.2. Геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуулын ажлын тайлан, нөөцийн тооцоо (цаашид "тайлан" гэх), ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл ба газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө (цаашид "ТЭЗҮ" гэх) зэрэгт Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс томилогдсон шинжээчийн ажлын хөлс тооцоход энэ жишгийг мөрдөнө.

Хоёр. Шинжээчийн ажлын хөлс тооцох

2.1. Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн геологи, уул уурхай, газрын тосны үр дүнгийн тайлан, ТЭЗҮ-д шүүмж, дүгнэлт гаргахаар томилогдсон шинжээчийн ажлын хөлсийг "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ыг үндэслэн тооцож олгоно.

2.2. Улсын төсвийн бус санхүүжилтээр гүйцэтгэсэн геологи, уул уурхай, газрын тосны үр дүнгийн тайлан, ТЭЗҮ-д шүүмж, дүгнэлт гаргахаар томилогдсон шинжээчийн ажлын хөлсийг тооцохдоо тухайн хуулийн этгээд болон шинжээч нар доорх аргачлалыг үндэслэн тохиролцож болно.

$$z = \left(\frac{\bar{c} + \frac{3}{4} \bar{c}}{160 \text{ ц}} \right) * t + b + a$$

z: Шинжээчийн ажлын хөлс

\bar{c} : Үндэсний статистикийн хорооноос гаргасан тухайн үеийн Уул уурхайн салбарын дундаж цалин

$\frac{3}{4} \bar{c}$: Салбарын нарийн мэргэжлийн инженерийн цалингийн итгэлцүүр

160 ц: Сарын дундаж ажлын цаг

t: Шинжээчийн нийт ажиллах цаг

b: Шинжээчийн зэргийн болон бусад нэмэгдэл

a: Шинжээчийн бусад зардал

Эсвэл хуулийн этгээд болон шинжээч нар Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцож болно.

2.3. Шинжээчийн ажлын хөлсний хэмжээг тогтоохдоо тухайн тайлан, ТЭЗҮ-д тусгагдсан нөөцийн хэмжээ, олборлох хүчин чадал зэрэг гол үзүүлэлтүүдэд үндэслэн шинжээчийн мэргэжлийн ур чадвар шаардах байдал, үүсэж болох эрсдэл, хүлээх хариуцлага, шинжээчийн дүгнэлт гаргах хугацаа зэргийг харгалзан үзнэ.

- 2.4 Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс томилогдсон шинжээч тухайн ажлыг гүйцэтгэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигч болон захиалагчтай гэрээ байгуулж ажиллана.
- 2.5 Талууд тухайн шинжээчийн ажлын төрөл, хэмжээ, ажлын хөлсний хэмжээ, хугацаа, татварын тухай гэрээнд тусгасан байна.
- 2.6 Энэ аргачлалыг стратегийн ордын тайлан, ТЭЗҮ-д шинжээч хийхэд хэрэглэхгүй бөгөөд талууд олон улсын жишгийн дагуу шинжээчийн ажлын хөлсийг тохирно.

--oOo--